

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн  
газар

Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Халдварт бус өвчний тандалт,  
сэргийлэлтийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Дэс түшмэл, Т3-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13  
дугаар баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэр, хэрэгжүүлэх, халдварт бус өвчнөөс  
сэргийлэх, хянах, тандалт судалгаа хийх, өвчлөлөөс сэргийлэх цогц арга хэмжээг  
хэрэгжүүлэх, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн  
үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Халдварт бус өвчнийг эрт илрүүлэх, нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулахад урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргэшилт арга зүйгээр ханган, хяналт тавин ажиллах.
- Халдварт бус өвчин болон өвчлелийг үүсгэж буй эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх, бууруулах чиглэлээр бүртгэл, мэдээлэл, судалгааны ажлыг хөгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах.
- Осол гэмтэл, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах арга хэмжээг зохион байгуулах, мэргэжилт арга зүйн удирдлагаар хангах.
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хетелбэр, бодлогын бичиг баримтыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх, мэргэжилт арга зүйгээр ханган ажиллах;</li> <li>Халдварт бус өвчнөөс сэргийлэх, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулах чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн ажиллах;</li> <li>Хүн амын дунд зонхилж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, уур бухимдал, сэтгэл гутрал, стрессээс сэргийлэх, өөрийгөө хянахад чиглэсэн мэдээлэл сургалт явуулах, зөвлөгөө өгөх ажлыг өргөжүүлэх;</li> <li>Халдварт бус өвчиний эрт илрүүлэг, үзлэгийн явцад дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжөөр хангаж ажиллах;</li> <li>Халдварт бус өвчиний урьдчилан сэргийлэх үзлэгийг мэргэжилт арга зүйгээр хангах, хянах, идэвхижүүлэх арга хэмжээг зохион байгуулах эрт хяналт хийж зөвлөмжөөр ханган</li> </ol>	Хэрэгжилтийн хувиар,  Сургалт сурталчилгааны тоогоор,  Зөвлөмж хэрэгжсэн байна.	Г, Т  Г, Т  Г, Х  Г, Х



	ажиллах;		
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн тайланд дүн шинжилгээ хийх;</p> <p>2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг судлах;</p> <p>3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчинүүдийн эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, лавлагаат тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;</p> <p>4. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;</p> <p>5. Хавдрын бүртгэл мэдээллийг сайжруулж, хяналтын нэгдсэн систем үүсгэх;</p> <p>6. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамtran ажиллах.</p>	<p>Дүн шинжилгээ хийсэн байна.</p> <p>Судалгааны дүн үр дүнгээр,</p> <p>Үнэлгээний хувиар,</p> <p>Хамtran ажилласан байгууллагын тоогоор,</p> <p>Бүртгэл мэдээллийн сантай болсон байна.</p> <p>Төрийн бус байгууллагын тоогоор,</p>	<p>Г, Х</p> <p>Г</p> <p>Г, Т</p> <p>Г</p> <p>Г, Т, Х</p> <p>Г</p>
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Аймгийн хэмжээнд осол, гэмтлээс сэргийлэх, хянах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>2. Осол гэмтэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шалтгаан нөхцөлд тандалт судалгаа хийж, хариу арга хэмжээ авах;</p> <p>3. Зонхилон тохиолдож буй осол, гэмтлийг бууруулахад чиглэгдсэн цогц арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамtran хэрэгжүүлж, үр дүнг тооцох;</p> <p>4. Осол гэмтлээс сэргийлэх талаар иргэд, олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны төлөвлөгөө гарган, аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах.</p>	<p>Хэрэгжилтийн хувиар,</p> <p>Арга хэмжээний тоогоор,</p> <p>Хамtran ажилласан байгууллагын тоогоор,</p> <p>Мэдээлэл, сургалт сурталчилгааны тоогоор,</p>	<p>Г, Т</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p> 

4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;</p> <p>2. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг мөрдөж ажиллах;</p> <p>3. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох;</p> <p>4. Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрдөж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;</p> <p>5. Жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллах;</p> <p>6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг хэлтсийн даргын емнэ хариуцна.</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилтээр, Стандартыг мөрдөж ажилласан байна.</p> <p>Оролцсон арга хэмжээний тоогоор, Ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан байна.</p> <p>Зөрчилгүй байна.</p> <p>Хэрэгжилтийн хувиар,</p>	Г Г Г Г Г Г
---------------------------	---	--	----------------------------

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	Эрүүл мэнд /091/.		
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Төрийн албанад 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх;</li> <li>- нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлгаха;</li> <li>- бусад.</li> </ul>	МОНГОЛ УЛС ДАУАЧИЛГАА МОНГОЛЫН ДАУАЧИЛГАА
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;</li> <li>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;</li> <li>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нэлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих.</li> </ul>	МОНГОЛ УЛС ДАУАЧИЛГАА МОНГОЛЫН ДАУАЧИЛГАА

		<ul style="list-style-type: none"> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;</li> <li>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> <li>- бүтээлч, санаачилгатай ажиллах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- нээлттэй, шударга байх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;</li> <li>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;</li> <li>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- комьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.</li> </ul>


#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> Байхгүй.	<u>Бусад харилцах субъект :</u> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн яам, агентлагийн холбогдох мэргэжилтэн,</li> <li>- Аймгийн Засаг даргын орлогч</li> <li>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,</li> <li>- Эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд,</li> <li>- Иргэн, хуулийн этгээд.</li> </ul>
--	---

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> <b>ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА</b>  <b>N.OYONTUYA</b> <b>2019 оны 11 дугаар сарын 22-ны өдөр</b>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зэвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> <b>Байгууллагын нэр:</b> <b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨвлөл</b> <b>Шийдвэрийн огноо: 2019.10.30</b> <b>Дугаар: 201</b>
<b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b> <u>Байгууллагын нэр:</u> <b>ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР</b> <b>Шийдвэрийн огноо: 2019.11.22</b> <b>Дугаар: a/49</b>	
 <b>ДАРГА ..... Д.ШИВААННУРДЭВ</b> <b>2019 оны 11 дугаар сарын 22-ны өдөр</b>	